

“ХҮНДЭТ ДОКТОР” ЦОЛ ГАРДУУЛАВ

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр ОХУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Виктор Васильевич Самойленко болон Канадын Торонтогийн их сургуулийн профессор Ольга Бакич нарт Монгол улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Хүндэт докторын цол олгов. Хүндэт докторын цол, өргөмжлөл гардуулах ёслол 2012 оны 11 дүгээр сарын 1-нд тус хүрээлэн дээр болж, Хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн гишүүд, ШУА-ийн тэргүүн дэд Ерөнхийлөгч Д.Рэгдэл болон ОХУ-аас Монголд улсад суугаа Элчин сайдын яамны дипломатууд, их дээд сургуулийн багш нар, хэвлэл мэдээллийн төлөөлөл оролцлоо. Уг ёслол дээр ОУСХ-ийн захирал доктор Л.Хайсандай хэлсэн үгэндээ ОХУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Виктор Васильевич Самойленко нь Монгол Улс, Оросын Холбооны улсын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлэх, Монгол дахь Орос судлалыг хөгжүүлэх үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулсан, мөн Канадын Торонтогийн их сургуулийн профессор Ольга Бакич нь Оросын нэртэй дипломатч И.Я.Коростовецийн Монголд хийсэн өдрийн тэмдэглэлийг нандигнан адгалж, өвлүүлэн Монголын түүх, Монгол-Оросын харилцааны судлалд үнэт нэмэр хандив оруулсныг тус тус онцлон тэмдэглэв.

Мэдээ бэлтгэсэн Ж.Орхон